**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН**

# ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр Дугаар А/96 Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.11.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг хэлтэс, салбарын дарга болон эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТ
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК
1115105450 2685221

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ

172101355

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны
03 дугаар сарын 04-ны өдрийн А/96
дугаар тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК
1115105450 2685221

# "ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт, давтамж, хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг ажилтнуудад сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт, хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ ( фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжит хэлбэрээр нийт ажилтнуудад хүргэх | Тухай бүр баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнах | Захиргаа удирдлагын хэлтэс, салбарууд |
| | | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах | Тухай бүр дэмжиж, хамтран ажилласан байх, салбар нэгж, орон, нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнах | |
| | | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллийг самбарт байршуулах | |
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах | Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлэх | Сургалтад ажилтнуудыг хамруулах санал, захиалга өгөх | |
| | | АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах | Сургалтад хамрагдсан албан хаагчийн нэрсийг гаргах | |
| | | Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан ажилтнуудад хүргэн шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнах | Төлөвлөгөөт хугацаанд сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | |
| 3 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх ; | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг тухай бүр АТГ-т хүргүүлэх | Захиргаа удирдлагын хэлтэс, салбарууд |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдэх | Тухай бүр хамтран ажиллан тайланг хүргүүлэх | Эрх бүхий албан тушаалтан |
| | | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах | Тухай бүр гэрээ хэлэлцээр, заалт тусгах | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх... г.м) | Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртлыг багасгах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах | Захиргаа удирдлагын хэлтэс, салбарууд |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, боловсруулж байгаа хууль, дүрэм, бодлогын баримт бичиг, журмын төсөлд ажилтнуудын болон сонирхогч бүлгийн саналыг тусгах арга хэмжээ авах<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулах, төсөлд ажилтнуудын санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх | Тухай бүр ажилтнуудтай харилцан санал солилцох | Захиргаа удирдлагын хэлтэс, салбарууд |
| | | Төсөлд ажилтнуудын болон сонирхогч бүлгээс санал өгөх боломжоор хангах | | |
| | | Төслийн талаарх албан хаагчид болон бусад этгээдээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах | | |
| | | Эрх бүхий этгээдээр батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах | | |
| 7 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байх<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9. | Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн дүгнэлтийг 05 дугаар сарын 01-ний дотор, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх (өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор шилэн дансны мэдээлэлд байршуулах) | Хуулийн хугацаанд хэрэгжилтийг хангуулж, иргэдэд, ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэх | Захиргаа удирдлагын хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Худалдан авах ажиллагаа, хянган нийлүүлэлтийн хэлтэс, салбарууд |
| | | Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох, татварын орлого, татварын бус орлогын талаар шилэн дансны мэдээлэлд байршуулах | | |
| | | Хандив, тусламжийн хэмжээ, түүнийг зарцуулсан тайлан хагас болон бүтэн жилээр гарган шилэн дансны мэдээлэлд байршуулах | | |
| | | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансны мэдээлэлд байршуулах | | |
| | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансны мэдээлэлд байршуулах | | |
| | | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шилэн дансны мэдээлэлд байршуулах. | | |
| | | Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц, байдлын талаар шилэн дансны мэдээлэлд байршуулах | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 8 | Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах, тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэл, тендерийн үр дүнг худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д бүрэн оруулах, байгууллагын цахим хуудсанд тодорхой байршуулах **Эрх зүйн үндэслэл:** · Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1; · Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; · Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6; · Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулах<br>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга гаргах<br>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэх (шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл)<br>Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг тайлагнах<br>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтыг мэдээлэх<br>Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнах | Тухай бүр цахим хуудсанд байршуулах | Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс, салбарууд |
| 9 | Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, ажилчдад мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажиллах **Эрх зүйн үндэслэл:** • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг www.able.mn болон бусад дотоод сүлжээнд байршуулан нийт ажилтнуудад шуурхай мэдээлж байршуулах | Тухай бүр | Мэдээллийн технологийн хэлтэс, салбарууд |
| 10 | Компаний нэгж дэх ажлын байр, албан тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн, АТГ-т хүргүүлж хянуулж хариуг авах ажлыг зохион байгуулах. **Эрх зүйн үндэслэл:** • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5. | Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч, бүртгэх<br>АТГ-т хүргүүлэн хянуулах<br>АТГ-аас ирүүлсэн ХАСУМ хянасан тухай албан бичгийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулах | Тухай бүр | Эрх бүхий албан тушаалтан |
| | | Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хянуулахаар ЭБАТ-д өгөх<br>АТГ-ын дүгнэлтийг үндэслэн томилох шийдвэрийг гаргах ажлыг зохион байгуулах | | Захиргаа удирдлагын хэлтэс, салбарууд |
| 11 | Мэдүүлэг гаргагч албан хаагчдын хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсоноос хойш болон томилогдсоноос хойш 30 хоногт (2019*, 2019+) багтаан ХАСХОМ-ийг мэдүүлэх ажлыг зохион байгуулах. **Эрх зүйн үндэслэл:** · Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3; · Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3. | Байгууллагын мэдүүлэг гаргагчид (шинээр томилогдсон) ХАСХОМ-ээ хугацаанд нь гаргаж мэдүүлэх<br>Цахим системд баталгаажуулах<br>ЭБАТ-д цаасан сууриар мэдүүлгийг хүлээлгэж өгсөн ХАСХОМ-ын бүртгэлийг цахим системд оруулах<br>Мэдүүлэг бүрдүүлэлтийн ажил цаг хугацаандаа зохион байгуулагдсан, зөрчилгүй байх | Хуулийн хугацаанд | Эрх бүхий албан тушаалтан |
| 12 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | Сул орон тооны зар | Тухай бүр шинэчилсэн цахим хуудсанд байршуулсан байх | Захиргаа удирдлагын хэлтэс |
| | | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх, журам<br>Ажилтнуудын хариуцсан ажил,үүргийн талаарх мэдээлэл | Цахим хуудсанд байршуулсан байх | |
| | | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Сар бүр цахим хуудсанд байршуулсан байх | |
| | Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлж, хэвших **Эрх** | Өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)<br>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны нэр, | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 13 | **зүйн үндэслэл:**<br>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;<br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; | • албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах<br>• Цахим хуудсанд байршуулан мэдээлэх | Тухай бүр цахим хуудсанд байршуулах | Захиргаа удирдлагын хэлтэс |
| 14 | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр (тушаал, тогтоол)-ийн нээлттэй, ил тод байдлыг хангах<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт), дүрэм, журам, заавар нь ил тод нээлттэй байх | Тухай бүр цахим хуудсанд байршуулсан байх | Захиргаа, удирдлагын хэлтэс,<br>Мэдээллийн технологийн хэлтэс |
| 15 | Байгууллагын ажилтны ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах, салбарын ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг мөрдөх,<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.1.6.3 | Компанийн төв удирдлага болон салбаруудын Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийн санг бүрдүүлэх, тайлагнах<br>Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах<br>Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах, Ёс зүйн зөвлөл, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах | Зөрчил илэрсэн тохиолдолд хууль, дүрэм журамд заасан хариуцлага хүлээлгэн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд тухай бүр мэдээлэх | Захиргаа, удирдлагын хэлтэс,<br>Ёс зүйн зөвлөл,<br>Хяналт мониторингийн хэлтэс,<br>салбарууд |
| 16 | Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.3.7.1 | Акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Тухай бүр хууль эрх зүйн актад тусгах | Санхүү, эдийн засгийн хэлтэс,<br>Хяналт мониторингийн хэлтэс |
| 17 | Тодорхой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулж шалгаруулах зэрэг шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа удирдах болон эрх бүхий албан тушаалтныг бүрэн хамруулах арга хэмжээ авах. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8 дахь заалт | Тусгай байгууллагаас олгож буй зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл)<br>Тусгай зөвшөөрөл, эрх олгох г.м бусад үйл ажиллагаатай эрхлэх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэсэн журамтай танилцах нөхцөлийг хангах<br>Тухайн зөвшөөрөл, эзэмшигчийн нэр хаяг эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг заавал тусгах | Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс,<br>Захиргаа удирдлагын хэлтэс |

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС